

Сүм хийд шинээр байгуулахад бүрдүүлэх бичиг баримт

1. Сүм хийд байгуулах, үйл ажиллагааг явуулах зөвшөөрөл авахыг хүссэн иргэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст дараах баримт бичгийг ирүүлнэ.
2. Тухайн шашны байгууллага байгуулах үндэслэл, хэрэгцээ шаардлага, үйл ажиллагааны онцлогыг тусгасан өргөдөл
3. Төр сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангасан дүрэм
4. Шашны байгууллага байгуулахаар санал нэгдсэн хүмүүсийн хурлын шийдвэр, дэлгэрэнгүй тэмдэглэл
5. Шашны байгууллага байгуулахыг анх санаачлагчид, удирдах зөвлөл, үүсгэн байгуулагчид, ажиллагсадын товч бүртгэл /ургийн овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, регистрийн дугаар, боловсрол, мэргэжил, эрхэлж байгаа ажил, төгссөн сургууль, хэрэв суралцаж буй бол тухайн сургуулийн нэр, гэрийн хаяг, утас, цахим шуудангийн хаяг, зөвшөөрснийг гэрчлэх гарын үсэг/
6. Үйл ажиллагаа явуулах байршил, газар эзэмших гэрчилгээ, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, хэрэв түрээсийн байранд ажиллаж байгаа бол түрээслэгчтэй хийсэн гэрээ, нотиратаар баталгаажуулсан хуулбарын хамт
7. Шашны байгууллагаас тухайн шашны зан үйлийг явуулахад шаардагдах ном, судар, бусад шаардлагатай хэрэгслийн жагсаалт, түүхийн үнэт өв эдлэлийн жагсаалт, хөрөнгө санхүүгийн хэмжээ, эх үүсвэр, тусламж, хандив, зардлын тооцоо
8. Шашны байгууллагын зорилго, шүтэж итгэдэг номлолын үндсэн үзэл санаа, үйл ажиллагааны зарчим, хамрах хүрээ, төрөл хэлбэр, гадаад харилцааны талаарх танилцуулга
9. Шашны байгууллагаас шүтэн бишрэгчид, итгэгчдийн дунд зохих ажлын гол агуулга, чиглэл
10. Тухайн шашны байгууллага байгуулахыг дэмжсэн баг, сумын Засаг даргын албан бичиг
11. Шашны байгууллагын номлол, сургаал айлдагч нь гадаадын иргэн бол тохирсон ангиллын оршин суух “SH”, зөвшөөрөл бүхий гадаадын иргэн, түүний цагдаагийн байгууллагын тодорхойлолт, ажиллаж байгаа газрын тодорхойлолт
12. Нэр давхацсан эсэхийг тодруулсан Улсын бүртгэлийн байгууллагын лавлагаа
13. Шинээр зөвшөөрөл авахад холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг авна.
14. Хэрэв дээр дурдсан баримт бичгийн бүрдэл дутуу бол материалыг хүсэлт гаргагчид буцаана.

**Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг
сунгуулахад бүрдүүлэх баримт бичиг**

Шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгахад дараах баримт бичгийг бүрдүүлж, Дархан сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн Ж.Хуланд ирүүлнэ. Үүнд:

1. Тухайн шашны байгууллагаас үйл ажиллагааныхаа хугацааг сунгуулах хүсэлтээ илэрхийлсэн албан бичиг
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Тухайн хугацаанд тус шашны байгууллагаас хийсэн ажлын товч тайлан
4. Зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргахаас өмнөх жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан
5. Хүсэлт ирүүлсэн шашны байгууллагын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн болон байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулсан эсэх, хэрэв өөрчлөлт орсон бол уг өөрчлөлтийн талаарх мэдээлэл
6. Тухайн шашны байгууллагад ажиллагсдын тоо
7. Тухайн шашны байгууллын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгуулахыг дэмжсэн баг, сумын Засаг даргын албан бичиг
8. Энэ журамд заасан баримт бичгийг тухайн сүм хийдийн үйл ажиллагаа явуулах хугацаа дуусахаас хоёр сарын өмнө сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.
9. Галын аюулгүй байдлын дүгнэлт
10. Хэрэв дээр дурдсан баримт бичгийн бүрдэл дутуу бол хүсэлт гаргагчид материалыг буцаана.

Хүсэлт гаргагч-Багийн Засаг дарга-Сумын Засаг дарга-Нийгмийн бодлогын хэлтэс-
ИТХурал шийдвэрлэнэ